



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.05.31 № 03/4542  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан МИАТ/20240402002 дугаартай “De anti /icing/ мөстөлтөөс хамгаалах шингэн/ TYPE IV төрлийн” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Галтхайрхан” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /цаашид “хууль” гэх/-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Галтхайрхан” ХХК-ийн гомдолд шалгарсан “Кемекс” ХХК нь тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1.2-т заасан барааны үйлдвэрийн гарал үүслийн гэрчилгээ, ТШЗ 20.1.3-т заасан чанарын шинжилгээний хуудсыг тус тус ирүүлээгүй, албан ёсны дистрибьютер “Мехлобат” ХХК-ийн танилцуулгад TYPE IV AIRCRAFT DEICING FLUID тусгай шингэний талаарх мэдээлэл огт байхгүй байгаа нь тус компанийг энэ төрлийн мөстөлтийн эсрэг шингэнийг нийлүүлэх боломжтой тухай хангалттай нотолгоо болохгүй, техникийн тодорхойлолтод заасан агаарын хөлгийн мөстөлт арилгах шингэний олон улсын стандартын шаардлагын талаарх мэдээлэл, химийн бодисын хадгалалтын хугацааны мэдээлэл, “FAA holdover time guidelines”-ийн шаардлагатай мэдээлэл, техникийн үзүүлэлтүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг тус тус ирүүлээгүй байхад гэрээ байгуулах эрх олгосон захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсаны дагуу захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Кемекс” ХХК-ийн ирүүлсэн тендерийг хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-ийн 3-т “Чанарын шинжилгээний хуудас /Үйлдвэрлэгчээс авч ирүүлэх/” гэж заасан байна.

“Кемекс” ХХК-ийн тендер “Clariant International Ltd” компанийн (ЕС) 1907/2006 журмын дагуу хийгдсэн 9 бүлэгтэй “Аюулгүйн өгөгдлийн хуудас”-ийг ирүүлсэн нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 18.2-т “бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана” гэж заасан.

Захиалагч тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд оролцогч санал болгож барааг нийлүүлэх боломжтойг нотлох баримт бичиг, нотолгоог шаардаагүй байх тул "Clariant International Ltd" компанийн албан ёсны дистрибьютер "Мехлобат" ХХК-ийн танилцуулгад TYPE IV AIRCRAFT DEICING FLUID тусгай шингэний талаарх мэдээлэл огт байхгүй байгаа нь тус компанийг энэ төрлийн мөстөлтийн эсрэг шингэнийг нийлүүлэх боломжтой тухай хангалттай нотолгоо болохгүй талаарх гомдол үндэслэлгүй байна.

3.Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 20.1-ийн 2-т "Барааны үйлдвэрийн гарал үүслийн бичиг" ирүүлэхээр заасан байна.

"Кемекс" ХХК-ийн тендерт Швейцар улсын "Clariant International Ltd" компанийн барааг санал болгосон байх бөгөөд тендерт барааны гарал үүслийг бичгийг ирүүлээгүй байхад тендер шалгаруулалтын баримт бичигт заасан дээрх шаардлагад нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.

4. Тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод "De/anti-icing, TYPE IV маркийн тусгай шингэн нь олон улсын SAE/AMS-1428, SAE/AMS-1424, ISO-11075, ISO-11075, ISO-11076, ISO-11078 стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн байна, тусгай шингэн нь олон улсын итгэмжлэгдсэн "AMIL" лабораториор баталгаажсан байхаас гадна байгаль орчинд хоргүй, хөрс, усанд бүрэн шингэдэг эко шингэн байна. Шингэний хадгалалтын хүчинтэй хугацаа нь нийлүүлэгдсэн өдрөөс хойш 21 сарын хугацаатай байна, манай улстай цаг агаарын хувьд ойролцоо олон улсын нисэх буудлуудад ашиглагдаж байгаа нь тодорхойлогдсон байна. TYPE IV төрлийн шингэн нь 2024-2025 оны өвлийн улиралд "FAA Holdover Time Guidelines" жагсаалтад орох боломжтой байх ёстой." гэж заасан байна.

Үнэлгээний хорооны 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хурлын тэмдэглэлээс үзэхэд "Кемекс" ХХК-ийн санал болгож буй бараа нь олон улсын итгэмжлэгдсэн "AMIL" лабораториор баталгаажсан эсэх, хадгалалтын хугацаа шаардлагад нийцэх эсэх, TYPE IV төрлийн шингэн нь 2024-2025 оны өвлийн улиралд "FAA Holdover Time Guidelines" жагсаалтад орох боломжтой эсэх зэрэг тендер шалгаруулалтын баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан дээрх шаардлагад нийцэх эсэх асуудлыг хянан үзээгүй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 01/1299 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Галтхайрхан" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

The image shows a handwritten signature in black ink over a rectangular official stamp. The stamp contains the text 'МОНГОЛ УЛС' (Mongolia) at the top, 'ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА' (State Court) in the middle, and 'Ж. ГАНБАТ' (J. Ganbat) at the bottom. The signature is written across the stamp, with the name 'Ж. ГАНБАТ' also appearing to the right of the stamp.

Ж. ГАНБАТ